



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар А/208

Бат-Өлзий сум

**Гэрээ байгуулах тухай**

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэг Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3.3.7, 4.5.3, 4.5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ажлын хэсгийн 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны дүгнэлтийг үндэслэн Орон нутгийн хөгжлийн сангийн малын тоо толгойн албан татварын хөрөнгө оруулалтаар Сумын төвд мал тарилгын хашаа барих ажлыг иргэн Д.Дорждэрэмтэй шууд худалдан авах аргаар гэрээ байгуулсугай.

2.Д.Дорждэрэмтэй гэрээ байгуулж, Сумын төвд мал тарилгын хашаа барих ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3.Зардалд шаардагдах 2,800,000 (хоёр сая найман зуун мянга) төгрөгийг гэрээнд заасны дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн малын тоо толгойн албан татвараас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын гэрээт нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН